

**“УЛААНСАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 11 дүгээр сарын 21 өдөр
Увс аймаг, Баруунтуруун сум
09 цаг 00 минут

Хуралд хүрэлцэн ирэгсэдийг бүртгэх бүртгэл 09 цаг 00 минутас эхлэв.

Хурал зохион байгуулах комисс: Хурлын ирцийг бүртгэж дуусаад ирцийг танилцуулж хурлын ирц бүрдсэн тухай тайлагнаж тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

Хурлын дарга: Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн ирцийн талаархи мэдээллийг хийж тогтоолоо танилцуулна уу.

Тооллогын комисс: Хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийг 08 цаг 30 минутанд эхэлж 09 цаг 00 минутанд хааж ирцийн бүртгэлийг гаргалаа. Ингээд та бүхэнд тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

“Монгол улсын компанийн тухай хууль”, “Улаансан” ХКомпанийн дүрмэнд заасан журмын дагуу бүх хувьцаа эзэмшигчдийн 60,98 хувь буюу 5 хувьцаа эзэмшигч хуралд ирсэнээр хурал хүчин төгөлдөр болохыг мэдэгдлээ.

Хурлын ирц:

1. Г.Лхагвасүрэн /ОА89032911 / -1250 ширхэг буюу 2,01 хувь
2. “Тулгат Чандмань баян” ХХК /4000471/ -6348 ширхэг буюу 10,2 хувь
3. Б.Батсайхан /ОЮ70091091/ - 3089 ширхэг буюу 4,97 хувь
4. Б.Ганболд /ОЭ58062371/-27031 ширхэг буюу 43,5 хувь /Өвлөх эрхээр/
5. Б.Давааням /ШЖ58012871/-200 ширхэг буюу 0,3 хувь нарыг бүртгэв

Нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 37918 ширхэг буюу 60.98 хувийн ирцтэй байна.

Хувьцаа эзэмшигчдийн ирц 60,98% байгаа тул холбогдох хууль, журам, дүрмийн шаардлагыг хангаж хурал хуралдахад бэлэн болсон байна.

Хурал хуралдсан огноо: 2022 оны 11 дүгээр сарын 21 өдөр

Хаана: Увс аймаг, Баруунтуруун сум, Соёлын төвийн байранд.

Хурлын дарга: Ганболдын Лхагвасүрэн

Хурал эхэлсэн хугацаа: 09 цаг 00 минутанд

Хурлын ирц:

1. Г.Лхагвасүрэн /ОА89032911 / -1250 ширхэг буюу 2,01 хувь
2. “Тулгат Чандмань баян” ХХК /4000471/ -6348 ширхэг буюу 10,21 хувь
3. Б.Батсайхан /ОЮУ70091091/ - 3089 ширхэг буюу 4,97хувь
4. Б.Ганболд /ОЭ58062371/-27031 ширхэг буюу 43,474хувь /өвлөх эрх/
5. Б.Давааням /ШЖ58012871/-200 ширхэг буюу 0,321хувь

Нийт хувьцаа эзэмшигчдийн 37918 ширхэг буюу 60,98 хувийн ирцтэй байна.

Хэлэлцэх асуудал:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож батлах
2. Асуулт, хариулт

Хурлын дэг:

1. Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гаргаж тооллогын комисс тогтоолоо танилцуулах -5 минут
2. Хурлыг нээж хурлын дарга Г.Лхагвасүрэн үг хэлэх -2 минут
3. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийг танилцуулах /5 минут/
4. Санал хураалт /15 минут/
5. Асуулт хариулт, санал шүүмжлэлийн таслах /2 минут/
6. Завсарлага, санал тоолж нэгтгэх /10 минут/
7. Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг танилцуулах /5 минут/
8. Хурлаас гарах шийдвэр (тогтоол)-ыг хэлэлцэж батлах /цаг тогтоохгүй/

Бүртгэлийн цаг: 08 цаг 30 минутаас эхэлж 09 цаг 00 минутанд дуусч тооллогын комисс ирцийн дүнгээ гаргав.

Тооллогын комиссоос хурлын ирцыг танилцуулж хуралд нийт хувьцааны 60,98 хувь буюу 37918 ширхэг хувьцааг эзэмшигч 5 хувьцаа эзэмшигч ирсэн тухай танилцуулж, Монгол улсын "Компанийн тухай хууль" болон "Улаансан"ХК-ийн дүрмийн заалтын дагуу хувьцаа эзэмшигчдийн хойшлогдсон хурал хуралдах шаардлагыг хангаж байгааг мэдэгдэв.

Хурал зохион байгуулах комисс: Хурал хуралдах шаардлагыг хангаж байгаа учир хурлын дарга Г.Лхагвасүрэн хурлыг нээв.

Хурлын дарга: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Сайхан намаржижи бийн уу? Та бүхэнд хурлын дэгийг танилцуулъя. /хурлын дэгийг уншиж танилцуулав/ Ээлжит бус хуралдуулах болсон шалтгаан нь ТУЗ-ийн нэг гишүүн маань тэнгэрт дэвшсэн учир гишүүдийг дахин сонгож баталж гүйцэтгэх захиралаа томилох зайлшгүй шаардлага үүссэнтэй холбоотой.

Ингээд ТУЗ-д нэр дэвшиж байгаа хнэр дэвшигчдийнхээ товч танилцуулгатай танилцъя. Та бүхэнд хэвлэмэл байдлаар тараасан байгаа тул би нэг бүрчлэн унших уу яах уу?

Б.Давааням: Өөрсдөө уншаад танилчихсан байгаа учраас уншиж танилцуулах шаардлагагүй гэж бодож байна.

Хурлын дарга: За тэгвэл тооллогын комисс маань саналын хуудсаар санал өгөх заавраа танилцуулаад саналаа хураае. Тооллогын комисс саналаа тоолох хооронд түр завсарлаад цайлцгае.

Хурлын дарга: За тооллогын комисс дүнгээ танилцуулна уу?

Тооллогын комиссын дарга: Саналын хуудсыг тоолсон тухай тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга: Та бүхэнд хурлаас гарсан тогтоолыг уншиж танилцуулъя. Хурлаас гарсан тогтоолыг хурлын дарга уншиж танилцуулж хувьцаа эзэмшигчдийн 100% саналаар баталж хуралд оролцогсодын 100 хувийн саналаар хурал өндөрлөв.

Хурал 10 цаг 05 минутанд өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн  Б.Булгаа

Хурлын тэмдэглэл нийт 3 /гурав/ хуудас